

## МОНГОЛ УЛСААС ХӨРШ ОРНУУДАЙ ХАРИЛЦАХ ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА: ӨНГӨРСӨН, ОДОО БА ИРЭЭДҮЙ

**Н.Батнасан\***

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд 1990-ээд оноос хойш Монгол улс болон хөрш орнуудын хоорондох эдийн засгийн гадаад харилцааны нөхцөл байдлыг үнэлж дүгнэн, улс орны хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн энэхүү харилцааг ойрын ирээдүйд өргөжүүлэх боломжийг судалж тусгалаа. Түүнчлэн улс орны үндэсний эрх ашгийн үүднээс хөрш орнуудтай харилцах харилцаанд анхаарвал зохих зарим асуудлыг хөндөж бичлээ.

**Түлхүүр үг:** Монгол-ОХУ-ын эдийн засгийн гадаад харилцаа, Монгол-БНХАУ-ын эдийн засгийн гадаад харилцаа, хөрш орнуудтай харилцах харилцааны хэтийн төлөв

### **Гурван улсын эдийн засгийн гадаад харилцааны өнөөгийн нөхцөл байдал**

Орос, Хятад улсууд нь манай оронтой нутаг дэвсгэрийн хувьд хил зэргэлдээ байршиж, түүх соёлын хувьд нягт харилцаатай хөгжиж ирсэн бөгөөд Монгол улс эдгээр орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтран ажиллаж ирсэн олон зуун жилийн түүх, уламжлалтай.

Дэлхийн социалист системийн задрал, зах зээлд шилжих шилжилт, 1990-ээд оны дунд үеэс эрчээ авсан даяарших үйл явц, Зүүн Өмнөд Ази, түүний дотор БНХАУ-ын эдийн засгийн түргэн хурдацтай өсөлт зэрэг нь манай орны зүгээс ОХУ, БНХАУ-тай харилцах харилцаанд томоохон өөрчлөлтийг авч ирсэн билээ.

Ялангуяа Монгол улсын гадаад худалдааны эргэлтэд 90 гаруй хувийг эзэлж байсан ЗХУ тарж бутран, ЭЗХТЗ-ийн үйл ажиллагаа зогссон нь социалист интеграцийн хүрээнд эдгээр орнуудтай нягт холбоотойгоор хөгжиж ирсэн Монгол улсад томоохон цохилт болсон юм. Монгол улсын экспортын гол зах зээл хумигдаж, дотоодын үйлдвэрлэл уналтад орсон төдийгүй импортын огцом

\*МУИС-ийн, Бизнесийн сургууль, Худалдааны хөтөлбөрийн профессор,  
(E-mail) batnasan\_n@hotmail.com

буурснаар дотоодын хэрэглээ хумигджээ. ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас манай улсад үзүүлж байсан зээл тусламж зогссон төдийгүй гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, техник технологийн шинэчлэл зогсонги байдалд орсон билээ. Чухам энэ үеэс Монгол улс дэлхийн бусад улс орнуудтай улс төр, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх асуудалд онцгойлон анхаарч эхэлсэн билээ.

Ерээд оны хүн бэрх үеэс Монгол улстай гадаад харилцаагаа хамгийн өндөр түвшинд хөгжүүлсэн улс орон бол БНХАУ юм. Тус улс нь дэлхийн социалист системийн задралтай холбоотойгоор үүссэн Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааны хоосон орон зайг нөхөж, эдүгээ манай улсын худалдаа эдийн засгийн гол түнш орон болоод байна. 2014 оны байдлаар хоёр орны хоорондох худалдааны эргэлт 6.8 тэрбум ам.долларт хүрч, БНХАУ нь Монголын нийт гадаад худалдааны нийт эргэлтэд 61.75%-ийг эзлэх болсон<sup>2</sup>. Мөн оны байдлаар Монгол улсын нийт экспортын 87.8%, нийт импортын 33.0% нь БНХАУ-д ногдож байв. 2014 онд БНХАУ-аас оруулсан шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 67.6 сая ам.долларын хэмжээнд байв.

1990-ээд оны эхэн үед саарч, улмаар зогсонги байдалд ороод байсан Монгол-Оросын харилцаа 2000 оны 11-р сард хийсэн ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины айлчлал, Зөвлөлтийн үеийн их өрийг шийдвэрлэсний дараахан үеэс хэмжээний хувьд сэргэх хандлагатай болсон. Хэдийгээр хоёр орны худалдааны хэмжээ бага зэрэг өсөлттэй байгаа боловч Монгол улсын гадаад худалдааны түргэн хурдацтай өсөлтөөс шалтгаалан худалдааны нийт эргэлтэд ОХУ-ын эзлэх хувийн жин буурсаар ирсэн. 2014 оны байдлаар хоёр орны хоорондох худалдааны нийт эргэлт 1.61 тэрбум долларт хүрч, Монголын нийт экспортын 1.07%, нийт импортын 29.59% нь ОХУ-д ногдож байлаа<sup>3</sup>.

Ийнхүү сүүлийн 20 гаруй жилийн туршид Монголын эдийн засагт Оросын нөлөө буурч, Хятадын нөлөө, оролцоо тасралтгүй өсөх хандлага тасралтгүй үргэлжилж байна. Хятадын асар том зах зээл манай үйлдвэрлэгчдэд томоохон боломжуудыг бий болгож, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байгаа ч гадаад эдийн засгийн харилцааны хувьд нэг орноос хэт хамааралтай нөхцөл байдлыг үүсгэлээ. Харин Монгол – Оросын харилцааны нөхцөл байдлыг авч үзвэл, сүүлийн 20 гаруй жилийн туршид бүрэлдэн бий болсон эдийн засгийн шинэ хэв маягийн бүтэц нь өмнөх тогтолцооны үед хоёр орны хооронд тогтоод байсан худалдагч ба худалдан авагчийн харилцааг өөрчилж, зэс, нүүрс, нефть гэх мэт олон ашигт малтмалын хувьд зах зээл дэх өрсөлдөгчид болгон хувиргасан байна.

БНХАУ, ОХУ нь олон улсын түвшинд чухал үүрэг гүйцэтгэдэг их гүрнүүдийнхээ хувьд дэлхийн хэмжээний бодлогыг зохицуулахад чухал

<sup>2</sup>ГЕГ “Гадаад худалдааны барааны гаалийн статистик мэдээлэл” 2014

<sup>3</sup>ГЕГ “Гадаад худалдааны барааны гаалийн статистик мэдээлэл” 2014

үүрэгтэй. Энэ хоёр орны хоорондох харилцаа нь 2001 оны 7-р сарын 16-нд байгуулагдсан “Сайн хөршийн, найрамдал, хамтын ажиллагааны гэрээ”, 2005 онд байгуулагдсан стратегийн түншлэлийн гэрээнд суурилдаг. Хоёр орон 2001 онд “Стратегийн түншлэлийн хэлэлцээр” байгуулсан боловч түүнийг хэрэгжих баталгааг бий болгож чадаагүй. Хэлэлцээрийг байгуулснаас хойш хэдхэн сарын дараа Москвад, дараа нь 2006 онд Бээжинд уулзалтууд зохион байгуулж, хэлэлцээрийн ач холбогдлыг үнэлэн “харилцан хүндэтгэх, адил тэгш эрхтэй байх, харилцан туслалдах, улс төрийн хувьд харилцан бие биенээ дээд зэргээр дэмжих” зэрэг үүрэг амлалтуудыг авсан байна<sup>4</sup>. Гэвч эдгээр гоё сайхан үгс нь Хятадын “энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим” (和平共处五项原则)-ыг хэрэгжүүлэх ажлын нэг хэсэг байснаас хэтрээгүй билээ<sup>5</sup>.

Хэдийгээр Орос, Хятад улсуудын найрсаг хөршийн харилцаа өргөжиж, гадаад худалдааны эргэлт нь 95.2 тэрбум ам.долларт хүрээд байгаа<sup>6</sup> боловч хүйтэн дайны жилүүдэд үүссэн харилцааны “мөс” өнөөдрийг хүртэл бүрэн хайлаагүй, харилцааны хэтийн төлөв нь “тодорхойгүй байдал”-тай, харилцан бие биенийхээ эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь төдийлөн өндөр бус байна. Хоёр талын харилцаанд үл ойлголцол байсаар ирсэн боловч сүүлийн жилүүдийн нөхцөл байдлаас үзэхэд асуудлыг шийдвэрлэх замаар харилцан итгэлцлийг бэхжүүлэх, харилцаа хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг чухалчлах байдал хоёр талын аль алинд нь ажиглагдах болсон.

Эдийн засгийн гадаад харилцаанд БНХАУ, ОХУ зэрэг хэт том орнуудын аль нэг нь, эсвэл зөвхөн хоёулаа давамгайлах байр суурийг эзэлбэл энэ нь Монгол шиг жижиг орны хувьд эдийн засгийн хараат бус байдлыг нь алдагдуулж, үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй. Тиймээс Монгол улс Орос болон Хятад улсуудтай харилцах харилцаандаа адил тэгш байр сууринаас хандах хандлагыг эрхэмлэж, “гуравдагч хөрш”-ийн бодлого, “олон тулгуурт гадаад харилцааны бодлого”-ыг хэрэгжүүлэх нь чухал юм.

### **Монгол улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал ба эдийн засгийн гадаад харилцааны зорилтууд**

Дэлхийд тэргүүлэх хэмжээнд хүрээд байсан Монголын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд саарсан нь дэлхийн зах зээлд олборлох үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн үнийн уналтын цикл эхэлсэнтэй шууд холбоотой. Уул

<sup>4</sup>Lo B., “Axis of Convenience: Moscow, Beijing and the New Geopolitics”, London, 2008, p.43.

<sup>5</sup>Энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим нь 1954 онд Энэтхэг-Хятады хооронд байгуулсан найрамдлын гэрээнд анх тусгагдсан. Эдгээр нь: нэгд, газар нутаг, тусгаар байдлыг харилцан хүндэтгэх; хоёрт, харилцан довтолхгүй байх; гуравт, талууд бие биенийхээ дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх; дөрөвт, талууд эрх тэгш байх; тавд, энх тайвнаар зэрэгцэн орших ... зэрэг зарчмууд юм.

<sup>6</sup>World bank 2014

уурхайн салбарын өсөлтийг дагалдан 2011 онд 17.3%<sup>7</sup>, 2012 онд 12.5%<sup>8</sup>, 2013 онд 11.6%<sup>9</sup>, 2014 онд 7.9%-иар өсч<sup>10</sup> байсан Монгол улсын ДНБ өмнөх онуудынхаас буурч 2015 онд 2.3%-иар өссөн урьдчилсан дүн гарчээ<sup>11</sup>.

Эдийн засгийн өндөр өсөлттэй жилүүдэд үлэмж хэмжээгээр тэлсэн гадаад худалдааны эргэлт ч буурах хандлагатай боллоо. 2011 онд 11.42 тэрбум ам.долларын хэмжээнд хүрээд байсан гадаад худалдааны нийт эргэлт жил дараалан буурч, 2015 онд 8.47 тэрбум ам.долларт хүрчээ. Экспорт 4.67 тэрбум ам.доллар<sup>12</sup>-ын хэмжээнд байгаа боловч түүний бүтцэд зэсийн баяжмал, цайрын баяжмал, нүүрс, төмрийн хүдэр, газрын тос, алт зэрэг 90 гаруй хувийг эзэлж байна.

Энэхүү нөхцөл байдлыг дүгнэж үзвэл, экспорт социализмын үеийнх шиг зохиомол хөнгөлөлтөд бус харин үндэсний үйлдвэрлэлийнхээ өрсөлдөх чадварт тулгуурлах болсон хэдий ч бүхэлдээ ганцхан салбараас хамааралтай, олборлох үйлдвэрлэлийн салбарын дэлхийн зах зээл дэх үнийн өсөлт бууралтаас хамаарч хэлбэлзэх болжээ. Эдийн засгийн өсөлт ч гадаад зах зээл дэх үнээс хамаарч хэлбэлздэг, эмзэг, тогтворгүй байдалтай болжээ.

Шилжилтийн эхэн үед буюу 1994 онд үндэсний хуримтлалын хэмжээ ДНБ-ий 21%-тай тэнцэх<sup>13</sup> хэмжээнд байсан бол энэ үзүүлэлт 2014 онд ДНБ-ий 34.6%-тай тэнцэх хэмжээнд байна<sup>14</sup>. Монголын эдийн засаг үндэсний үйлдвэрлэлийнхээ өрсөлдөх чадвар, харьцангуй давуу талд тулгуурлаж, хуримтлал болон хөрөнгө оруулалт хэмжээний хувьд өмнөхөөсөө өсч, эх үүсвэрийн хувьд дотоодын нөөц боломждоо илүүтэй тулгуурлах болсон нь томоохон амжилт юм. Хэдий тийм боловч сүүлийн жилүүдэд улсын гадаад өр төлбөр өсч, зарим эх сурвалжаас авсан мэдээгээр 21.6 тэрбум ам.долларт хүрч, үндэсний эдийн засгийн цаашдын өсөлтөд сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрсэн нь эдүгээ санаа зовоох асуудлуудын нэг болоод байна.

Өнөөгийн Монголын эдийн засагт нүүрлэсэн хүндрэл бэрхшээлтэй байдлыг хямралын түвшинд хүрсэн гэж хэлэхгүй боловч түүнийг даван туулах арга замыг тодорхойлоход бэрхшээлтэй байна. Ийнхүү нэг талаас, гадаад зах зээл дээр экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ унаж, ойрын үед сэргэх төлөвгүй байгаа бол нөгөө талаас дэлхийн улс орнуудад нүүрлэсэн эдийн засгийн хямралт байдлын улмаас гадаад, дотоодын хөрөнгө оруулалт

<sup>7</sup>ҮСХ “Монгол улсын статистикийн эмхтгэл” 2011

<sup>8</sup>ҮСХ “Монгол улсын статистикийн эмхтгэл” 2012

<sup>9</sup>ҮСХ “Монгол улсын статистикийн эмхтгэл” 2013

<sup>10</sup>ҮСХ “Монгол улсын статистикийн эмхтгэл” 2014

<sup>11</sup>УБСЕГ 2015

<sup>12</sup>МУГЕГ “Гадаад худалдааны барааны гаалийн статистик мэдээлэл” 2014

<sup>13</sup>ҮСХ “Монгол улсын статистикийн эмхтгэл” 1990

<sup>14</sup>ҮСХ “Монгол улсын статистикийн эмхтгэл” 2014

хумигдаж, эдийн засаг зогсонги байдалд орлоо.

Олон улсын байгууллагуудын зүгээс 2016 онд Монголын эдийн засгийн өсөлтийн талаар өөр хоорондоо нэлээд зөрүүтэй таамаглалуудыг хийж байгаа боловч тэдгээрийн аль нь ч эдийн засгийн өсөлтийг 5%-иас давж гарна гэж үзэхгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлт саарсан сүүлийн жилүүдийн хандлага 2016 онд үргэлжлэх болов уу гэсэн таамаглал давамгайлж байна.

Дэлхийн банк өнгөрсөн оны сүүлээр Монголын эдийн засгийн өсөлтийн талаар хийж байсан таамаглалаа өөрчилж, гадаад зах зээл дэх эрдэс бүтээгдэхүүний үнийн уналт, Оюутолгойн олборлох баяжмалд агуулагдах зэсийн агууламжийн бууралт, олборлох үйлдвэрлэлийн бус салбаруудын өсөлт саарсан зэргээс шалтгаалан 2016 онд Монголын ДНБ ердөө 0.8 орчим хувь өсөх болов уу гэсэн таамаглал дэвшүүлжээ<sup>15</sup>. Үүнээс өмнө тус банк 2016 онд ДНБ 4.1 орчим хувиар өсөх байх гэсэн таамаглалыг дэвшүүлээд байсан билээ. Олон улсын санхүүгийн өөр нэг томоохон байгууллага болох ОУВС 2016 онд Монголын ДНБ 0.4 орчим хувиар өснө<sup>16</sup> гэсэн таамаглал хийжээ. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт 2016 оны дунд үеэс эхлэх тул ирэх оны ДНБ-ий өсөлтийн хувь хэмжээ 3.0 хувьд хүрнэ гэсэн таамаглалыг дэвшүүлж байсан Азийн хөгжлийн банк бол таамаглалаа өөрчилж, 0.1 хувь болгон бууруулсан байна<sup>17</sup>. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк нэлээд өөдрөг таамаглал дэвшүүлж, ДНБ-ий өсөлтийг 2016 онд 5.0 хувьд хүрнэ<sup>18</sup> гэж үзжээ.

2016 оны эдийн засгийн өсөлтөд эерэгээр болон сөргөөр нөлөөлөх олон хүчин зүйлс байгааг энд дурдах хэрэгтэй болов уу. Гадаад зах зээлийн нөхцөл байдал, экспортын гол нэрийн барааны үнээс гадна зэсийн олборлолтын дийлэнх хэсгийг хийж буй Оюутолгойн ордод баяжмал дах зэсийн агууламж багатай хэсэгт олборлолт хийгдэхээр болсон нь экспортын орлогыг бууруулах магадлалтай.

Эдийн засагчдын хүрээнд 2015 онд дэлхийн эдийн засаг сэргэнэ гэсэн хүлээлт байсан боловч ОХУ, Хятад, Бразиль зэрэг томоохон орнуудад эдийн засгийн өсөлт саарч, дэлхийн эдийн засгийн өсөлт таамаглаж байсан хэмжээнд хүрсэнгүй. Үүнтэй уялдаатайгаар хөгжиж буй орнуудын огцом өсөлтийн мөчлөг дуусч буй талаар судалгаа шинжилгээний хүрээнд яригдах болов.

Дэлхийн зах зээлд эрдэс бүтээгдэхүүний гол худалдан авагч БНХАУ-д

<sup>15</sup>World bank 2016

<sup>16</sup>IMF 2016

<sup>17</sup>ADB 2014, 2016

<sup>18</sup>EBRD 2015

эдийн засгийн өсөлт саарч байгаа нь эрдэс бүтээгдэхүүний экспорт зонхилдог манай орны экспортын орлогыг одоо төсөөлж байгаа хэмжээнээс ч бууруулж болох эрсдлийг араасаа дагуулж байна. Энэ бүхнээс үзэхэд 2016 онд гадаад худалдаанаас орох валютын орлого өнгөрсөн оныхоос төдийлөн нэмэгдэхээргүй байгаа юм.

Монгол улсын эдийн засгийн өсөлт саарч, гадаад өр төлбөр нэмэгдсэнтэй холбоотойгоор Засгийн газар томоохон орд газруудыг эргэлтэд оруулах замаар нөхцөл байдлыг өөрчлөхийг оролдож байна. Дэлхийд томоохонд тооцогдох, 35.8 сая тн зэс, 1.4 мянган тн алтны нөөц Оюутолгойн<sup>19</sup>, 6.5 тэрбум тн нүүрсний нөөцтэй Тавантолгойн<sup>20</sup> ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар тэдгээрийн шууд болон дам нөлөөгөөр эдийн засгийн өсөлт хурдсах, экспортын орлого өсөх зэрэг зарим нааштай өөрчлөлт гарах нь илэрхий. Засгийн газар 2015 онд Дубайд Оюутолгойн зэсийн орд газарт далд уурхайн хэсэгт оруулах хөрөнгө оруулалтын гэрээг хөрөнгө оруулагч талтай байгуулсан төдийгүй Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах асуудлаар идэвхтэй ажилаж байна.

Томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах нь чухал боловч энэ нь нэлээд эрсдэлтэй алхамд тооцогдохоор байгаа юм. Учир нь нэг талаас улсын гадаад өр зээл нэлээд өндөр хэмжээнд хүрч, томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх боломж хязгаарлагдсан тул Монгол улсын “Ашигт малтмалын тухай” хуулийн 5.4-т заасан “улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувь”, 5.5-д заасан “улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх” хувьцааг төр эзэмших, төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг орд газрыг ашиглах гэрээгээр тодорхойлно гэж заасан хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх боломжгүй болоод байна. Нөгөө талаар 2015 оны сүүлээр Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын томоохон байгууллагуудаас гаргасан судалгаагаар Монгол улсын нийт экспортод 90 орчим хувийг эзэлдэг зэс, цайр, төмөр, алт, нүүрс, нефть гэх мэт олборлох үйлдвэрлэлийн салбарын үнэ 2025 оныг хүртэл төдийлөн өсөхгүй гэсэн прогноз хийснээс<sup>21</sup> үзэхэд, олборлох үйлдвэрлэлийн салбарт томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд үр ашиг бага, эргэн төлөгдөх магадлал

<sup>19</sup>AMEC Minproc Ltd “Oyu Tolgoi Technical Report” November 2009

<sup>20</sup>Ministry of Mineral Resources and Energy, Mongolia 2010

<sup>21</sup>World bank 2015, IMF 2015

муу болохыг харуулж байна.

Монгол улсад нөөц баялагт тулгуурласан, харьцангуй давуу тал бүхий 2 том салбар бий. Тэдгээр нь нэгд, нэхмэл сүлжмэл, арьс шир боловсруулах, мах сүүний үйлдвэрлэл гэх мэт мал аж ахуйд тулгуурласан үйлдвэрлэлийн салбарууд, хоёрт, нүүрс, алт, зэс, нефть гэх мэт олборлох үйлдвэрлэлийн салбарууд юм.

Даяаршин буй дэлхий ертөнцөд Монгол улс өөрийн харьцангуй давуу тал бүхий үйлдвэрлэлдээ тулгуурлаж байж амжилттай өрсөлдөх нь гарцаагүй юм. Үүний тулд харьцангуй давуу тал бүхий түүхий эдэд боловсруулалт хийж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх олборлох үйлдвэрлэлийн болон ХАА-н салбаруудаа түшиглэсэн боловсруулах үйлдвэрлэлийн кластеруудыг хөгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Нөхцөл байдлаас дүгнэж үзэхэд, манай оронд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого нь худалдааны гол түнш орон Хятадын ашиг сонирхолтой зөрчилддөг бөгөөд урд хөршийн өсөн нэмэгдэж буй эрэлт нь түүхий эдийн экспортыг урамшуулж, Монголд боловсруулах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ямар нэгэн хэмжээгээр саад учруулж байдаг. Харин Орос улсын экспортын өсөлт дэлхийн зах зээл дээр олборлох үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, манай улсын экспортын борлуулалтад нөлөөлж байдаг. Үүнээс үзэхэд, Монгол улсад олборлох үйлдвэрлэл болон энэ салбарын түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын аль аль нь хөрш орнуудтай харилцах харилцаанд тодорхой хэмжээгээр нөлөөтэй байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын гадаад өр нэмэгдэж, гадаадын хөрөнгө оруулалт буурсны зэрэгцээ дэлхийн зах зээлд олборлох үйлдвэрлэлийн салбарын үнэ их хэмжээгээр уналаа. Тиймээс ойрын жилүүдэд макро эдийн засгийн бодлогын хүрээнд төсвийн зарлагыг хумих, тарифыг нэмэгдүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг хамгаалж бэхжүүлэх, улмаар үйлдвэрлэлийн салбаруудыг бий болгох, гадаад өрийн удирдлагыг сайжруулах зэргээр эдийн засгийн өсөлтийг бий болгох, урт хугацаанд эдийн засгийг сэргээхэд чиглэсэн өөрчлөлтүүдэд илүүтэй төвлөрч ажиллах шаардлагатай байгаа юм. Түүнчлэн валютын нөөцийг нэмэгдүүлэх боломж хомс байгаа тул тодорхой хязгаарын хүрээнд гадаадын банкинд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох асуудлыг ойрын үед шийдвэрлэх шаардлагатай болов. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр валютын нөөцийн хомсдлыг даван туулах, зээлийн хүү буурах, хөрөнгө оруулалт өсөх зэрэг эдийн засгийн цаашдын өсөлтөд чухал ач холбогдол бүхий өөрчлөлтүүд явагдана.

Эдийн засгийн хөгжлийн стратеги бодлогын хүрээнд тавигдаж буй эдгээр

зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улс хөрш орнуудтайгаа харилцах бодлогодоо харьцангуй давуу талдаа тулгуурласан олон салбар бүхий эдийн засгийг хөгжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг урт хугацаанд хадгалж чадах ирээдүйн хөгжлийн баттай үндэс суурийг тавих асуудлуудад анхаарч, цаашид хөрш орнуудтайгаа урт хугацаанд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нарийвчилсан стратеги төлөвлөгөөг боловсруулан гаргах нь чухал боллоо.

### **Монгол – ОХУ, Монгол – Хятадын эдийн засгийн гадаад харилцааны цаашдын төлөв**

Даяаршлын үйл явц гүйнзгийрэхэд худалдааны либеральчлал чухал үүрэгтэй. Орчин үед худалдааг либеральчлах үйл явц нь нэгдүгээрт, улс орнууд гадаад худалдаандаа тогтоосон хориг саадуудаа багасгах, хоёрдугаарт, нэг бүс нутгийн улс орнууд өөр хоорондын худалдаанд тогтоосон хориг саадуудаа цуцлах, гуравдугаарт, худалдааны олон талт гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэн, тэдгээрийг дагаж мөрдөх гэсэн үндсэн хэлбэрүүдтэйгээр явагдаж байна.

Монгол, ОХУ, БНХАУ улсууд нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнууд бөгөөд хоорондын худалдааны харилцаагаа тус байгууллагын дүрэм журамд нийцүүлэн явуулдаг. Түүнчлэн Гадаад хэргийн яамдын түвшинд албан ёсны статустай зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, гурван талын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар зөвшилцдөг уламжлалтай.

Сүүлийн жилүүдэд хөрш гурван улс өөрсдийн гадаад худалдааны түнш орнуудтайгаа Чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) байгуулах асуудалд ихээхэн ач холбогдол өгөх болсон. Тухайлбал, БНХАУ нийт 11 оронтой ЧХХ байгуулсан ба 5 оронтой ийм төрлийн хэлэлцээр байгуулахаар ажиллаж байгаа бол харин ОХУ хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүн орнуудтай Гаалийн холбоо байгуулсан. БНХАУ, ОХУ нь хоорондоо ЧХХ байгуулаагүй боловч Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, БРИКС зэрэг олон улсын байгууллагын хүрээнд хамтран ажиллах болсон. Манай орны хувьд 2015 онд Япон улстай “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” байгуулсан.

Өнөөгийн нөхцөлд Монгол, Хятад, Орос улсуудын улс төрийн харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хүрсэн гэж үздэг боловч эдийн засгийн харилцаа нь ЧХХ байгуулах хэмжээнд хараахан хүрээгүй юм. Энэ нь зарим судлаачдын үзэж байгаагаар<sup>22</sup> нэгд, Орос-Хятад улсуудын соёл иргэншил, шашин шүтлэг, зан төлөвийн ялгаа нь харилцааны саад бэрхшээлүүдийг

<sup>22</sup>Grzegorz Niemczyk “The Rising Dragon and Wounded Bear: Analysis of Modern Sino-Russian Political & Economic Relations” Cracow University of Economics Discussion Papers Series CUE DP 2012, No. 5 (15), p.101



үүсгэж байдаг, хоёрт, хоёр орны хоорондох харилцаанд өнгөрсөн үеийн түүх, үйл явдлууд “харилцааны мөс” үүсгэж байдаг, гуравт, хоёр орны хоорондох худалдаа эдийн засгийн харилцаа Оросын хувьд алдагдалтай, Азийн бүс нутагт нөлөөгөө аажмаар алдаж буй Орос улс өөрийн байр сууриа энэ бүс нутаг дах нөлөөгөө хүч түрэн нэмж буй Хятад улсад сул тавьж өгөхийг хүсдэггүй зэрэгтэй холбоотой юм.

Монгол улс хэт том гүрнүүдтэй ЧХХ байгуулах нөхцөлд тэнцвэргүй худалдаа хийгдэх, тэнцвэргүй харилцаа үүсэх магадлал өндөр хэмжээнд байгаа тул манай улсын зүгээс энэ асуудалд туйлын болгоомжтой хандаж ирсэн. (Хүснэгт №1) Байгуулсан тохиолдолд хэлэлцээрийн хүрээнд Монгол мэтийн жижиг буурай орон өөрийнхөө ашиг сонирхлыг хамгаалах нь бэрхшээлтэй асуудал юм. ОХУ болон БНХАУ-ын хувьд Монголын зах зээл хэмжээний хувьд маш бага бөгөөд энэ утгаараа ЧХХ байгуулах нь эдийн засгийн хувьд ач холбогдол муутай.

Орос, Хятадтай ЧХХ байгуулахгүй байх нь энэ хоёр орноос хамаарах хамаарлыг сул байлгах, улмаар техник технологи өндөр хөгжсөн бусад улс орнуудтай найрсаг харилцаагаа хөгжүүлэх замаар өрсөлдөх чадвараа сайжруулах, өрнөдийн томоохон улс гүрнүүдийн улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг бий болгох замаар тэдний тусламж дэмжлэгийг авах, улмаар тусгаар тогтнолоо баталгаажуулах гэсэн Монгол улсын олон тулгуурт гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлэх гол арга зам юм.

**Хүснэгт 1.** Монгол улсын гадаад худалдаанд хөрш орнуудын, хөрш орнуудын гадаад худалдаанд Монгол улсын эзлэх хувийн жин, 2014 оны байдлаар

	Монгол улсын гадаад худалдаанд хөрш орнуудын эзлэх хувь	Хөрш орнуудын гадаад худалдаанд Монгол улсын эзлэх хувь					
		Нийт эргэлт	Экспорт	Импорт	Нийт эргэлт	Экспорт	Импорт
1	ОХУ	14.64	1.07	33.12	0.22	0.33	0.02
2	БНХАУ	62.07	87.80	29.92	0.13	0.07	0.22

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв (International trade center) – өөс гаргасан 2014 оны гадаад худалдааны статистик мэдээлэлд тулгуурлан тооцов.

Гадаад худалдааны өнөөгийн бүтцээс харахад, Хятад улс нь Монголын экспортын түүхий эдийг худалдан авагч, ОХУ нь экспортын зах зээл дэх өрсөлдөгч гэж хэлж болохоор байна.

Монголын экспорт нь эрдэс түүхий эд зонхилсон, цөөн нэр төрлийн бараа

түүхий эдээс бүрдсэн бүтэцтэй байгаа бол импортод нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн дийлэнхи хувийг эзэлж байна. Эсрэгээр БНХАУ аж үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эд, тоног хэрэгслийг импортоор авч, нэмүү өртөг шингэсэн, олон нэр төрлийн эцсийн бүтээгдэхүүнийг гол төлөв экспортолож, бодлогын хувьд эцсийн бэлэн бүтээгдэхүүн экспортолоход анхаарч байна. Харин ОХУ-ын нийт экспортын 60-70 хувийг нь нефть, нүүрс, төмөр, ган хөнгөн цагаан, алт, алмаз, никель, мод зэрэг байгалийн гаралтай бараа түүхий эд эзэлдэг бөгөөд үүгээрээ манайхтэй нэлээд төсөөтэй. Ялгаатай нь ОХУ байгалийн ашигт малтмалынхаа дийлэнх хэсгийг эцсийн боловсруулалтад оруулж, бэлэн бүтээгдэхүүн хэлбэрээр худалдаалдаг. ОХУ-ын импортод машин, тоног төхөөрөмж голлох хувийг эзэлж, эдгээрийг гол төлөв БНХАУ-аас худалдан авч байна<sup>23</sup>.

Бидний судалгаагаар ОХУ, БНХАУ-д манай улсаас нийлүүлэх боломжтой бүтээгдэхүүний жагсаалтад БТКУС-ийн 26, 05, 51, 71, 41, 74, 02, 25-р бүлгийн буюу байгалийн баялагт түшиглэсэн, мал аж ахуйн гаралтай түүхий эд багтаж байна. Эдгээрээс 26, 05 бүлгийн барааны хувьд харьцангуй давуу тал хамгийн өндөр, өрсөлдөх чадвар сайтай байгаа бол нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнүүд болох 61, 57 бүлгийн бараа бүтээгдэхүүний хувьд сүүлийн жилүүдэд өрсөлдөх чадвар нь сулрах хандлагатай болсон<sup>24</sup>.

БНХАУ нь БТКУС-ийн 40 гаруй бүлгийн хувьд экспорт харьцангуй давуу талтай байгаагийн дийлэнх нь нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн байна. Эдгээрээс 20, 63, 68, 69, 70, 73, 86 дугаар бүлгийн бараа манай импортын харьцангуй давуу талтай давхцаж байгаа тул эдгээрийг Монгол улс импортлох магадлал өндөр. Харин ОХУ нь эрдэс түлш, никель бараа, мод, модон эдлэлийн экспортын хувьд харьцангуй давуу талтай байгаа ба эдгээрээс эрдэс түлш, үр тариа нь манай импортын харьцангуй давуу талтай давхцдаг. Манай улсын зүгээс ОХУ-д 02, 25 гэсэн хоёрхон бүлгийн буюу мах, жоншийг экспортлох боломжтой ба ЧХХ-ийн хүрээнд мал эмнэлэг, эрүүл ахуй, хорио цээр болон тээвэрлэлтийн талын бэрхшээлүүдийг шийдвэрлэж чадвал мах болон хүнсний дайвар бүтээгдэхүүний экспортыг өргөжүүлж болохоор байна<sup>25</sup>.

Хэрвээ Орос, Хятад улсад Монголоос экспортлосон бараанаас алт, зэс, нүүрс, молибден, цайр, хар төмөрлөг, нефть зэргийг хасч тооцвол, олборлох үйлдвэрлэлийн бус салбарын жилийн экспорт 200 – 300 сая долларт эргэлдэж

<sup>23</sup>МУИС, ШУА-иас хамтран хэрэгжүүлсэн “БНХАУ, ОХУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, ач холбогдол” сэдэвт бодлогын судалгаа. Улаанбаатар хот. 2014 он. ху 207-2014

<sup>24</sup>МУИС, ШУА-иас хамтран хэрэгжүүлсэн “БНХАУ, ОХУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, ач холбогдол” сэдэвт бодлогын судалгаа. Улаанбаатар хот. 2014 он. ху 207-2014

<sup>25</sup>МУИС, ШУА-иас хамтран хэрэгжүүлсэн “БНХАУ, ОХУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, ач холбогдол” сэдэвт бодлогын судалгаа. Улаанбаатар хот. 2014. ху 207-2014

байгаа юм<sup>26</sup>.

Хятад болон ОХУ-аас Монгол улсад оруулсан хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбар болон худалдаа, нийтийн хоолны салбарт орсон дүн гарчээ. Хөрөнгө оруулалтын нөхцөл байдалд хийсэн судалгаагаар Хятад, ОХУ-аас Монголд хийж буй хөрөнгө оруулалт нь олборлох үйлдвэрлэлийн бус салбаруудыг хөгжүүлэх манай улсын ашиг сонирхолтой төдийлөн нийцэхгүй байгаа нь харагддаг.

Орос, Хятад улстай ЧХХ байгуулах замаар гадны хөрөнгө оруулалтыг ихээр татаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Орос, Хятадад худалдаалан эдийн засгийн өсөлтийг түргэтгэх боломжтой хэмээн үздэг судлаачид бий. Гэвч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг зардал дээр тээвэрлэлтийн өртөг зардлыг нэмж тооцвол, ийм бараа өрсөлдөх чадвар сайтай байж чадахгүй юм. Харин электроникс, машины үйлдвэрлэл, хүнд аж үйлдвэр өндөр хөгжсөн Япон, БНСУ, АНУ зэрэг Өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудтай ЧХХ байгуулах нь Монгол улсын олон тулгуурт гадаад бодлогын ерөнхий чиг шугамд нийцэж байгаа төдийгүй өрсөлдөх чадварыг бий болгоход тустай байж болно.

Монгол улс МАА-н үйлдвэрлэлийн харьцангуй давуу талдаа тулгуурлан, малын мах, сүү, арьс шир, түүнчлэн үс ноосыг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ХАА-н үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх замаар эдийн засгаа төрөлжүүлж, хүмүүст ажлын байрыг бий болгох стратеги бодлогыг хэрэгжүүлэх нь чухал юм. Ийм бодлогын хүрээнд дэлхийн тэргүүлэх хөгжилтэй орнуудын техник, технологийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг нь татах тааламжтай нөхцлийг бүрдүүлэхийн зэрэгцээ ОХУ, БНХАУ-ын зах зээлд экспорт хийх боломжуудыг эрж хайх шаардлагатай.

Одоогийн нөхцөлд ОХУ, БНХАУ-тай дамжин өнгөрөх тээвэрлэлт, эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ хэлцлийг байгуулан ажиллаж болох юм. Монголын экспортын өнөөгийн бүтцэд томоохон хувийг эзэлж буй уул уурхайн түүхий эдийг улс дамнуулан худалдаалах нь тээвэрлэлтийн өндөр өртөг зардал шаарддаг тул төмөр замын салбарт гэрээ хэлцэл байгуулж, гуравдагч орны зах зээлд нүүрс, зэсээ худалдах боломжийг нээх хэрэгтэй. Түүнчлэн нүүрсний томоохон орд газруудыг түшиглэсэн цахилгаан станцуудыг барьж байгуулан, эрчим хүчээ Хятадын зах зээлд нийлүүлэх өргөн боломж бий. Боловсруулсан өнгөт болон хар төмөрлөгийг ч Хятад улсад худалдах боломж бий. Харин одоо яригдаж буй Хятадын банкуудад Монгол улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох тухай санаа нь энэ улсаас хараат байдлыг улам бүр нэмэгдүүлэх эрсдэлтэй.

---

<sup>26</sup>Зохиогчийн тооцоо

Монгол улсын үйлдвэрлэлийн харьцангуй давуу тал, Орос улсын импортын эрэлт зэргээс үзэхэд эрүүл ахуй, мал эмнэлэг, хорио цээрийн асуудлыг шийдэж чадвал мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн, малын гаралтай үс ноос зэргийг ОХУ-д экспортлох боломж хамгийн өндөр байгаа юм. Оросоос Хятад руу байгалийн хий дамжуулах хоолойг Монголын нутаг дэвсгэр дээгүүр бариулах ажлыг гэрээ хэлцлийн хүрээнд шийдвэрлэж, урт хугацаанд Орос улстай эрх тэгш хамтран ажиллах боломжоо дээшлүүлэх нь чухал байна.

### **Дүгнэлт**

Эдийн засгийн гадаад харилцааны зөв бодлогыг амжилттай хэрэгжүүлж чадвал тэр нь эдийн засгийнхаа өсөлтийг дэмждэг болохыг олон улс орны туршлага нотолж байна. Түүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хэрэгжүүлэх бодлогын улс орны хөгжлийн стратегитэй нийцэх нийцэл, гол түнш улс орнуудын сонголт, тодорхой улс оронтой хэлэлцээр байгуулснаар урт болон дунд, богино хугацаанд бий болох давуу болон сул талууд, энэхүү харилцаанаас улс орны эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл, эдийн засгийн салбарууд, бүс нутгууд, хүн амын орлогын бүлгүүдэд хэрхэн нөлөөлөх зэргийг урьдчилан тооцсон байх шаардлагатай.

Монгол улсаас хөрш орнуудын талаар баримтлах эдийн засгийн гадаад харилцааны бодлого нь түнш орнууд дахь тарифын болон тарифын бус хориг саадуудыг арилгах, гадаад дотоод дахь тээвэрлэлтийн өндөр өртөг зардлыг бууруулах замаар олон улсын эдийн засгийн харилцаанд илүү идэвхтэй байр сууринаас оролцох боломж нөхцлийг бүрдүүлэхэд чиглэх ёстой. Ялангуяа энэ бодлого олборлох үйлдвэрлэлийн бус салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.

Монгол улс хүний хөгжлийн бэрхшээлтэй асуудлуудаа шийдвэрлэж, эдийн засагтаа тооны бус харин чанарын, эргэлтийн шинжтэй өөрчлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Одоогийн түүхий эдэд суурилсан, нэмүү өртөг багатай, гадаад орчноос хүчтэй хамаарал бүхий цөөхөн салбар бүхий эдийн засгийг өндөр технологи, мэдлэгт суурилсан, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл давамгайлсан, олон салбар бүхий орчин үеийн эдийн засаг болгож хөгжүүлэх асуудал энэ хүрээнд тавигдаж буй үндсэн гол зорилт билээ. Ийм бодлогын хүрээнд ирээдүйд улс орны эдийн засгийг авч явах шинэ салбаруудын хөгжлийн үндэс суурийг тавих, энэ хүрээнд биотехнологи, нефтьхими, атомын болон сэргээгдэх эрчим хүч, мэдээллийн технологи болон өөр бусад манай нөхцөлд хөгжүүлж болох өндөр технологийн шинэ залуу салбаруудад хөрөнгө оруулах зайлшгүй шаардлага бий. Тиймээс түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн салбарт харилцах бодлогыг юуны өмнө олборлох үйлдвэрлэлийн түүхий эдээ боловсруулах чиглэлээр хөрөнгө оруулалт технологийн шинэчлэл

хийх, дотоодын тээвэр логистикийн нөхцлийг сайжруулах асуудалд чиглүүлэх нь чухал байна.

Тээвэрлэлтийн өндөр өртөг зардалтай Монгол шиг орны нөхцөлд зайнаас хамаарал багатай үйлдвэрлэл, технологийг бий болгох, нутагшуулах асуудалд нухацтай анхаарах нь чухал байна. Үүний тулд хөрш орны тэргүүлэх сургуулиудад иргэдээ сургаж чадавхижуулах, шинжлэх ухаан, технологид хөрөнгө оруулалтыг татах замаар улс орны ирээдүйн хөгжлийн үндэс суурийг бүрдүүлэх нь чухал байгаа юм.

Хөрөнгө оруулалтын бодлогодоо гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудлыг бус харин түүнийг тогтоон барих, үр өгөөжийг нь хүртэхэд чиглэсэн өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай. Үүний тулд юуны өмнө, үндэстэн дамнасан корпорациуд (ҮДК) татвар, гаалийн орлогыг зувчуулах арга хэрэгсэл болсон “шилжих үнэ”-ийг зохицуулах зохицуулалтыг бий болгох, ҮДК-ийн толгой болон охин компанийн хооронд бараа, түүхий эд, ногдол ашгийг шилжүүлэх зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг хамтатган авч үзэх нь чухал байна. Энэ ажлын зарим хэсгийг хөрш орнуудтайгаа гэрээ хэлцлийн хүрээнд шийдвэрлэхийг эрмэлзэх хэрэгтэй.

### **Ашигласан материал**

- Albertino Alesina, Enrico Spolaore and Romain Wacziarg “Trade, Growth and the size of countries” Handbook of Economic Growth, Volume 1B. 2005
- Arvind Panagariya “Preferential Trading Arrangements, Trade, and Growth” presentation at the joint World Bank-Central Bank of Chile Conference “The Future of Trade Liberalization in the Americas” on March 22 and 23, 2004 in Santiago, Chile.
- Athanasios Vamvakidis “Regional Integration and Economic Growth” The World Bank Economic Review. vol. 12, NO. 2: 251-70
- Banerjee.A.V., Newman. A.F., “Credit, Growth, and Trade Policy” 2004
- Bellacqua J., “The Future of China-Russia Relations”, University of Kentucky, 2010.
- Cheng, Kevin C., Growth and Recovery in Mongolia During Transition, IMF Working Paper WP/03/217, Washington D.C., November. 2003
- Dollar.D and Kraay.A “Trade, growth and poverty” The Economic Journal, 114 (February), F22–F49. 2004.
- Davis.G.A., “Extractive Economies, Growth, and the Poor” Springer-Verlag Berlin Heidelberg 2009
- Francisco Rodriguez and Dani Rodrik “Trade policy and economic growth: A sceptic’s guide to the gross-national evidence” Working paper series No.7081. National Bureau of Economic Research. Cambridge 1999

- Grzegorz Niemczyk “The Rising Dragon and Wounded Bear: Analysis of Modern Sino-Russian Political & Economic Relations” Cracow University of Economics Discussion Papers Series CUE DP 2012, No. 5 (15)
- Gylfason.T “Nature, power, and growth” CESifo working paper No 413., 2001
- Gylfason.T, Zoega.G., “Natural resources and economic growth” Central Bank of Chile. Working paper No 142., 2002
- Halit Yanikkaya “Trade openness and economic growth: a cross-country empirical investigation” Journal of Development Economics 72 (2003) 57– 89., October 2002
- Harry Bloch, Sam Hak Kan Tang “Deep determinants of economic growth: institutions, geography and openness to trade” 2006
- Lo B., “Axis of Convenience: Moscow, Beijing and the New Geopolitics”, London, 2008.
- Osmani. S.R. “Towards an employment oriented pro-poor development strategy for Mongolia: A Background paper” UNDP Mongolia, 2006
- Pasha.H.A., “Pro-poor policies” UNESCAP 2002
- Pedro.A.M “Mainstreaming mineral wealth in growth and poverty reduction strategies” ECA policy paper No 1. 2004
- Rodrik.D, Grossman.G., Victor Norman., “Getting Interventions Right: How South Korea and Taiwan Grew Rich” Economic Policy, Vol. 10, No. 20. pp. 53-107. Apr., 1995
- Roemer.M and Gugerty.M “Does economic growth reduce poverty?” Technical paper. Harvard Institute for International Development. March 1997
- Ross.M “How does mineral wealth affect the poor” 2003
- Rosser.A., “The Political Economy of the Resource Curse: A Literature Survey” IDS working paper 268. 2006
- Shantayanan Devarajan; Chalongphob Sussangkarn “Effective Rates of Protection when Domestic and Foreign Goods are Imperfect Substitutes: The Case of Thailand “ The Review of Economics and Statistics, Vol. 74, No. 4. (Nov., 1992), pp. 701-711.
- UNDP (2002), “Mongolia: Industrial and Trade Development Policy Review”, Project Report MON/02/003/A/08/37, November
- WTO, UNCTAD International Trade Center “Trade statistics” 2000-2015
- МУИС, ШУА-иас хамтран хэрэгжүүлсэн “БНХАУ, ОХУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, ач холбогдол” сэдэвт бодлогын судалгаа. Улаанбаатар хот. 2014 он. №БС -13/06
- Просвирнов. С., “Миграционные связи Амурской Области и Китайской Народной Республики на рубеже XX-XXI веков”, Проблемы Дальнего Востока №1, 2009, с.72
- ҮСХ., “Монгол улсын статистикийн эмхтгэл” 1990-2014
- ГЕГ “Гадаад худалдааны барааны гаалийн статистик мэдээлэл” 1995-2014
- Монгол банк “Монгол банкны жилийн тайлан” 1995-2014